



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/13/

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллэз өвчний тандалт шинжилгээний зардалд нийт 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН